



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.РАХЫМБЕК ТАНАА

2026 0325 № 381
танай _____-ны № _____-т

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр байсан.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхгүй нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой аудитын нотлох баримт олж авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулга, сумын Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлан, баримт материалыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүйгээс аудитын дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 8 дугаар зүйлийн 8.9.2, 54 дүгээр зүйлийн 54.3, 54.4, 54.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан "Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

832605000442

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЖЕНИСБЕК

